

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

**“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК, “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ”  
ХК-ИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР  
ДҮН, ХУВЬЦАА ХУВААРИЛАЛТ, НОГДОЛ АШИГ ОЛГОЛТ**

2018 он



## Агуулга

|   |   |
|---|---|
| Агуулга .....   | 2 |
| Аудитын нэр, код .....  | 3 |
| Аудит хийх үндэслэл, бүрэн эрх .....                                  | 3 |
| Аудитын зорилт .....  | 3 |
| Хамрах хүрээ .....  | 3 |
| Үндсэн мэдээлэл .....   | 4 |
| Эрсдэлийн үнэлгээ .....   | 5 |
| Аудитын арга зүй .....  | 6 |
| Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд .....             | 6 |
| Аудитын хугацаа .....   | 7 |
| Аудит хийх багийн бүрэлдэхүүн .....                                   | 7 |
| Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам | 7 |
| Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц .....                                | 7 |

*Хавсралт 1. Эрсдэлийн үнэлгээ*

*Хавсралт 2. Асуудлын шинжилгээ*

*Хавсралт 3. Аудитын арга зүй*

*Хавсралт 4. Аудитын дэлгэрэнгүй хөтөлбөр*

*Хавсралт 5. Аудитын үр өгөөжийн төлөвлөлт*



## **ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

|        |  |
|--------|--|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт |
| УИХ    | Улсын Их Хурал                                   |
| ҮАГ    | Үндэсний аудитын газар                           |
| ХК     | Хувьцаат компани                                 |
| ХХК    | Хязгаарлагдмал хариуцлагатай компани             |



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



## АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

### Аудитын нэр:

“Эрдэнэс монгол” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн, хувьцаа хуваарилалт, ногдол ашиг олголт

### Аудитын код:

ГАГ-2018-11-ГА

### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаалаар батлагдсан ҮАГ-ын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

### Аудитын зорилт:

“Эрдэнэс монгол” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн, хувьцаа хуваарилалт, ногдол ашиг олголтын талаар аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэх,
- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэх,

### Хамрах хүрээ:

Аудитад “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Техник, эдийн засгийн үндэслэл, 2016, 2017 оны үйл ажиллагааны болон уулын ажлын төлөвлөгөө, тайлан мэдээ, санхүүгийн баримт материалуудаас түүврийн аргаар сонгон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Улсын бүртгэл, оюуны өмчийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хөрөнгийн бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Орон нутгийн засаг, захиргааны нэгж зэрэг байгууллагуудыг хамруулан шалгана.

### Үндсэн мэдээлэл:

“Эрдэнэс Монгол” ХХК нь 2007 оны 2 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд болон стратегийн ач холбогдол бүхий эрдэс баялгийн ордыг ашиглахтай холбоотой харилцаанд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан.

“Эрдэнэс Монгол” ХХК нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүд болон тэдгээртэй хамаарал бүхий дэд бүтцийн бүтээн байгуулалт, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төрд



ногдох хувь, төрийн мэдлийн хувьцааг эзэмшиж, тэдгээрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь өргөтгөж ашигт ажиллагааг сайжруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө босгох, нэмүү өртөг бий болгох боловсруулах үйлдвэрийн төслүүдийг хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, компаниудын үйл ажиллагаанд Засгийн газрын бодлогыг уялдуулах зэргээр нэгдсэн стратеги, дирдлагаар хангах үйл ажиллагаа явуулж байна.

Өнөөдрийн байдлаар компани нь “Эрдэнэс Таван толгой” ХК, “Эрдэнэс Оюу толгой” ХХК, “Багануур” ХК, “Шивээ Овоо” ХК, “Мон-Атом” ХХК, “Эрдэнэс Шивээ Энержи” ХХК, “Эрдэнэс Метан” ХХК, “Эрдэнэс Ассет менежмент” ХХК-иудын 50 буюу түүнээс дээш хувийн хувьцааг эзэмшиж байна. Мөн “Оюу толгой” ХХК-ийн Монголын талын 34 хувийг өөрийн охин компаниар дамжуулан эзэмшиж, Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн автозамын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан ажилладаг “Гашуун сухайт авто зам” ХХК-ийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн үндсэн дээр байгуулан ажиллуулж байна.

Таван толгойн нүүрсний орд нь 7.4 тэрбум тонн нөөцтэй бөгөөд үүнээс 5.1 тэрбум тонн нь коксжих нүүрс, 2.3 тэрбум тонн нь эрчим хүчний нүүрс байна. Эрдэнэс Тавантолгой ХХК нь 2011 оноос хойш Цанхийн зүүн болон Баруун уурхайгаас нийт 24.8 сая тонн нүүрс олборлосон.

2011 оноос хойш 22.1 сая тонн нүүрс экспортолсоноос 2016 оны байдлаар 7.5 сая тонн нүүрс экспортолсон. 2017 онд борлуулалт 9.2 сая тонн, борлуулалтын орлого 526.3 сая ам.доллар, 2018 онд борлуулалт 10.9 сая тонн, борлуулалтын орлогыг 534 сая ам.доллар, Монгол Улсын нийт нүүрсний экспортын 32 хувьд хүргэхээр тус тус төлөвлөсөн байна.

Эрдэнэс Тавантолгой ХХК нь байгуулагдсанаас хойш 2016 оны эцэс хүртэлх хугацаанд улсын төсөвт 261.7 тэрбум төгрөгийн татвар төвлөрүүлсэн бөгөөд 2017-2020 онд 334.4 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, 2.3 тэрбум ам.долларын орлого, улсын төсөвт 514.1 сая ам.долларын татвар төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Компани байгуулагдсанаас хойш дотоодын аж ахуйн нэгжээс 1.1 орчим их наяд төгрөгийн худалдан авалт хийсэн бөгөөд нийт өр төлбөрийн 91 хувийг “Чалко” компанийн урьдчилгаа төлбөрийн дүн, “ТТJV” компанийн өр төлбөр, Худалдаа хөгжлийн банкны зээл эзэлж байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны эзэмшил, хувь хэмжээг тогтоох асуудлаар 2008-2013 оны хооронд Засгийн газрын нийт 5 тогтоол гарсан бөгөөд өнөөдрийн байдлаар компанийн нийт зарласан хувьцааны 85.19 хувийг төр, 0.06 хувийг аж ахуйн нэгж, 14.75 хувийг иргэд эзэмшиж байна.

#### **Эрсдэлийн үнэлгээ:**

Урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “дунд” гэж үнэлэв. (Эрсдэлийн үнэлгээг хавсралт №1-д үзүүлэв)

#### **Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах,



нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна. (Асуудлын шинжилгээг хавсралт №2, аудитын арга зүйг хавсралт № 3-т үзүүлэв).

Аудитыг хэрэгжүүлэхэд ордын техник эдийн засгийн үндэслэл болон хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх хөндлөнгийн шинжээч, зөвлөхийг ажиллуулахдаа сонирхлын зөрчилгүй хуулийн этгээд, иргэнтэй гэрээ байгуулж, ажлын даалгаврын дагуу гүйцэтгүүлж хамтран ажиллана.

#### **Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд:**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /2014-2025 он/,
- Ашигт малтмалын тухай хууль,
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай,
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль,
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль,
- Татварын ерөнхий хууль,
- Гаалийн тухай хууль,
- Газрын тухай хууль,
- Газрын хэвлийн тухай,
- Хөрөнгө оруулалтын тухай хууль,
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Усны тухай хууль,
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль,
- Компанийн тухай хууль,
- Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль,
- Хөрөнгө оруулалтын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Бусад холбогдох журам, арга-лал, стандартууд

#### **Аудитын хугацаа:**

Аудитын төлөвлөгөөг 2018 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн дотор батлуулж, талбарын ажлыг 2018 оны 8 дугаар сарын 10-ны өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хүртэл гүйцэтгэн, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтыг хийлгэж, 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн дотор Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар баталгаажуулан Улсын Их Хуралын Эдийн засгийн болон Төсвийн Байнгын хороо, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

#### **Аудит хийх багийн бүрэлдэхүүн:**

УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Одгэрэл удирдаж, аудитын менежер Б.Саруул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Долгорсүрэн, Б.Хишигтогтох, Р.Цолмон, аудитор М.Наранжаргал, Д.Баатархуяг, Б.Даваабаатар, М.Доржмаа, И.Туяадарь нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэнэ. (Аудитын хөтөлбөрийг хавсралт №4-т үзүүлэв).



## Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь аудитын хураангуй, оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох газруудын санал, аудитын зөвлөмж гэсэн агуулгаар үндсэн зорилтын хүрээнд бичигдэнэ.

Аудитын тайланг ҮАГ-ын Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар батлуулан Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд хөтөлбөрт заасан хугацаанд хүргүүлнэ.

### Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц:

Аудитад дараах санхүү, хөрөнгийн нөөцийг зарцуулахаар төлөвлөв. Үүнд:

А. Хүний нөөц: ҮАГ-аас 8 хүн – 864 хүн/өдөр  
Гэрээт ажилтан 1 хүн – 108 хүн/өдөр

Б. Санхүүгийн нөөц : Цалин – 6,490.0 мян/төгрөг  
Бичиг хэрэг – 2,000.0 мян/төг

В. Томилолтын зардал: 6 хүн, 27 хоног 9,860.0 мян/төгрөг

Г. Зөвлөх, шинжээчийн зардал: 37,000.0 мян/төгрөг  
Лабораторийн шинжилгээний зардал. 3,440.0 мян/төгрөг

Д.Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, фото аппарат  
болон бусад техник хэрэгсэл.

### АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ

#### Хянаж зөвшөөрсөн:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С.ОЮУНБИЛЭГ

#### Боловсруулсан:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.ОДГЭРЭЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.САРУУЛ

АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛГОРСҮРЭН  
Б.ХИШИГТОГТОХ  
Р.ЦОЛМОН

АУДИТОР

М.НАРАНЖАРГАЛ  
Д.БААТАРХУЯГ  
М.ДОРЖМАА  
Б.ДАВААБААТАР  
И.ТУЯАДАРЬ